

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

2010 оны 6 дугаар сар 4

Сайн Байцгаана уу,

Та бүхэн ОУДС дээр болж байгаа арга хэмжээнүүдэд оролцож байгаа гэдэгт би итгэлтэй байна. Бид төгсөлтийн баяраа амжилттай тэмдэглэж өнгөрүүллээ. Энэ жил төгсөж байгаа арван долоон сурагч маань эцэг эх, найз нөхөд, багш нарынхаа хамтаар баяраа тэмдэглэж дипломоо гардаж авлаа. Энэ үдэш төгсөлтийн баяраа тэмдэглэсэн сайхан арга хэмжээ болж өнгөрлөө.

Сурагчдын маань Төгсөлтийн үдэшлэг Бямба гарагийн орой болсон. Уламжлал болгон зохиогддог энэ үдэшлэг нь бидний байнга хүсэн хүлээж байдаг сайхан арга хэмжээнүүдийн нэг байдаг. Энэ үеэр сурагчид маань гоёлын дашинз, костюмаа өмсөж томчууд шиг биеэ авч явахыг харахад бахархалтай байдаг. Олон нийтийн газар өөрсдийгөө соёлтой, зөв авч явж байгаа тэднийг хараад та бүхэн манай сурагчдаар бахархах болно.

Спортын тэмцээнд оролцсон сурагчдын хүлээн авалт Баасан гарагийн орой, 5-р ангийн сурагчдын үзэсгэлэн 6 сарын 8-нд болно.

Хичээлийн жил дуусч байгаатай холбогдуулан ирэх жилийн элсэлт, төлбөрийн талаар та бүхэнд мэдээлэлүүд очиж байгаа. Хоёр зуу гаруй сурагчид сургуульдаа эргэн ирж суралцана гэдгээ бидэнд албан ёсоор мэдэгдээд байна.

Та бүхэн номын сангийн номнуудаа буцаан өгч, кафетериягийн төлбөрөө төлсөн байхад анхаараарай. Эдгээр зүйлсийг одооноос эхэлж анхаарсанаар бидний цаашдын бичиг цаасны ажил удаашрахгүй хялбар хийгдэхэд тустай байх болно.

Бид нэг жилийг амжилттай дуусгаж байна. Энэ хичээлийн жилийг амжилттай дуусгахад цаг зав, хүчин чармайлт гаргаж тусалсан бүх хүнд би талархал илэрхийлж байна.

Захирал Greg Rayl

ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:

6 сарын 5	Дэлхийн Байгаль Орчны өдөр
6 сарын 8	5-р ангийн Үзэсгэлэн Гала Үдэш
6 сарын 10, 11	3-р ангийн Кемп аялал Гүн Галуут
6 сарын 10-12	5-р ангийн Кемп аялал Хустайн Нуруу
6 сарын 14	2-р ангийн Кемп аялал Нүхт-өдрөөр
6 сарын 15	1-р ангийн Кемп аялал Тэрэлж Бүүвэйт-өдрөөр
6 сарын 16	Нийт сургуулийн спортын өдөрлөг
6 сарын 17	Хичээлийн жилийн сүүлчийн өдөр сурагчид 12 цагт тарна

2010-2011 оны хичээлийн жилийн элсэлтийн талаар

2010-2011 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийн нэхэмжлэлийг та бүхэнд явуулсан. Та бүхэн хүүхдийнхээ сургалтын төлбөрийг 8-1-ний дотор хугацаанд нь төлөөрэй.

Номын Сангийн Номнууд: Сурагчид номын сангийн бүх номнуудыг буцаасан байх ёстой. Хэрвээ гэрт тань номын сангийн номнууд байвал Даваа гарагт авчирч хураалгана уу.

ОУДС-ийн 9, 10-р ангийн сурагчдад PSAT тестийн талаарх мэдээлэл бүхий захидлыг өгч явуулсан. Энэ шалгалтыг амжилттай өгсөнөөр NMSQT тэтгэлэгт шалгарах боломжтой. Бид сурагчиддаа 11-р анги төгсөхөөсөө өмнө энэ шалгалтыг өгөх боломжийг бүү алдаасай гэж зөвлөх байна. PSAT шалгалтыг амжилттай өгсөн манай төгсөх ангийн нэг сурагчийн авсан оноо олон улсын хэмжээнд өндрөөр үнэлэгдсэн. Захидлын хавсралтаас та бүхэн дэлгэрэнгүй мэдээллийг аваарай. Энэ жилийн PSAT шалгалтыг ОУДС дээр 2010 оны 10 сарын 16-нд авна.

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Өнгөрсөн Баасан гарагт төгсөлтийн баяр, Бямба гарагт Төгсөлтийн Үдэшлэг амжилттай болж өнгөрлөө. Бид энэ үеэр сургуулиа амжилттай төгссөн сурагчдаараа бахархаж байлаа. Сурагчдын

Зөвлөлийн хамт олон төгсөлтийн үдэшлэгт бэлтгэх ажлыг амжилттай сайн зохион байгуулсанд талархал илэрхийлье.

6-р ангийн сурагчид ядуурлын талаарх сэдвийн хүрээнд Цэцэглэх Ирээдүй төвийн хүүхдүүдийн дунд тусгай төсөл хэрэгжүүлж байгаа. Та бүхэн тэдний зохион байгуулсан ажлын талаар өөрсдөөс нь асууж сонирхоорой.

Хичээлийн жил дуусах дөхөж байна. Энэ үеэр бид сурагчдыг сайн унтаж амарч зөв хооллож өвдөхгүй байх нь чухал гэж үзэж байна. Ядарч, цангаж өлсөж байгаа үед хичээлдээ анхаарахад хүндрэлтэй байдаг. Цаг агаар хуурай халуун байгаа энэ үед ус сайн ууж байх хэрэгтэй гэдгийг та бүхэн сурагчдад зөвлөөрэй. Ус сайн уухгүй бол цаг агаарын огцом өөрчлөлтөнд бие махбод дасан зохицоход хүндрэлтэй байдаг. Сурагч бүхэн өөрсдийн усны саваа өдөр болгон тогтмол авчирч байгаа гэдэгт бид итгэлтэй байна.

Та бүхэн Хүүхдийн баярыг сайхан тэмдэглэсэн гэдэгт би итгэлтэй байна. Энэ өдөр цаг агаар дулаахан байсан болохоор та бүхэн гадуур гарцгааж цагийг сайхан өнгөрүүлсэн байхаа. Хаа сайгүй ээж аавынхаа гараас хөтлөөд явж байгаа хүүхдүүдийг харахад сайхан байсан. Ирэх жил хүүхдийн парк ашиглалтанд орж хүүхдүүд уламжлал ёсоор паркт очиж тоглоно гэдэгт итгэлтэй байна. Амралтын өдрүүдээ сайхан өнгөрүүлээрэй.

Дунд Сургуулийн Эрхлэгч, Betsy Hanselmann

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

4-р ангийн сурагчид Даваа гарагт Fraternity de Notre Dame асрамжийн хүүхдүүдэд зориулсан баярын арга хэмжээ зохион байгууллаа. “Market Day” сэдвийн хүрээнд хуримтлуулсан орлогын мөнгөө тэд тус асрамжийн хүүхдүүдэд гардуулж өгсөн.

4-р ангийн сурагчид маань Лхагва гарагт Кемп аялалдаа явцгаалаа. Гүн Галуутын зусланд очиж тэд цагийг хөгжилтэй өнгөрөөсөн. Та бүхэн энэ Мэдээг хүлээж аваад уншиж байх хугацаанд тэд аялалдаа сайн яваад ирж байгаа гэдэгт би итгэлтэй байна.

Лхагва гарагт 2-р ангийн сурагчид “Tikki Tikki Tembo” тоглолтоо ээж аавдаа болон бэлтгэл анги, 1-р ангийн сурагчдад сонирхууллаа. 2-р ангийн сурагчиддаа болон дуу хөгжмийн багш Сарантунгаад баяр хүргэе!

Charlie and the Chocolate Factory жүжгийн цөөн тооны CD үлдсэн байгаа. Хэрвээ та бүхэн CD худалдаж авах хүсэлтэй бол хүүхдийнхээ нэр, ангийг бичсэн дугтуйг 3000 төгрөгийн хамт ангийн багшид нь ирүүлнэ үү.

Бага Сургуулийн Эрхлэгч Jan Wiggins

Англи Хэлний Зуны Зуслан

Хэрвээ хүүхэд тань зуны амралтаараа Улаанбаатарт байж англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх сонирхолтой байгаа бол Америк сургууль дээр 6 сарын 21-7 сарын 9-ний хооронд зохиогдох Англи хэлний зуны зусланд бүртгүүлээрэй. Дэлгэрэнгүй мэдээллийг 348888 дугаараар Амраатай холбогдож авч болох буюу www.asu.edu.mn вэб сайтаас авч болно.

ОУДС-ийн Нийт Хамт Олонд Баярлалаа

Verbist Төвийн хүүхдүүдэд лаазалсан хоол хүнсний бүтээгдэхүүн хандивлаж тусалсан нийт багш, сурагчид, эцэг эхчүүдээ баярлалаа. Сургуулийн хамт олон 130 ширхэг лаазалсан хүнс цуглуулж тус төвийн хүүхдүүдэд 6 сарын 1-ний баярын өдөр гардуулж өглөө. Гоёлын хувцсаа өмссөн тус төвийн хүүхдүүд бидэнд концерт тоглож сонирхуулсан. Энэ төвийн хүүхдүүдэд сайн дураараа үйлчлэх олон боломж бидэнд байгаа. Хүүхдүүд англи хэл сурахын зэрэгцээ шинэ тоглоом сурч, үлгэр домог сонсох дуртай. Хэрвээ та бүхэн энэ төвийн хүүхдүүдэд цаг зав гарган туслах хүсэлтэй бол Sister Lucille-тэй 99718805 дугаарын утсаар холбогдоно уу. Энэ төслийг цаашид үргэлжлүүлэхийг бид ирэх жилийн 8-р ангийн сурагчдад уриалах болно.

Та бүхэнд баярлалаа.

8-р ангийн сурагч Tiffany and Vanessa Luehrs

ОУДС Номтой Нөхөрлөх Долоо Хоногийн хүрээнд хамгийн олон ном уншсан анги сурагчдыг шалгаруулах уралдаан зарласан. Энэ үеэр сурагчдыг номтой нөхөрлүүлж уншсан номын тоогоор урамшуулах хандивын арга хэмжээг тэдний эцэг эх, төрөл төрөгсдийн дунд зохион байгуулж энэ арга хэмжээнээс бид гурван сая төгрөгийн хандив цуглуулсан. Энэ хандивын нэг хэсгээр бид Цэцэглэх Ирээдүй төвийн бэлтгэл ангийн сурагчдад бүрэн хэмжээний хичээлийн хэрэглэл бүхий сурагчийн цүнх худалдан авч бэлэглэлээ. Энэ бэлтгэл ангийн хөтөлбөр нь энгийн цэцэрлэгт орох боломжгүй хүүхдүүдэд хичээл зааж сургуульд бэлтгэх боломжийг олгодог юм.

Олон ном уншиж шалгарсан зарим сурагчид Бэлтгэл ангийнханы төгсөлтийн баярт уригдаж оролцон тэдэнд хичээлийн хэрэгсэл бүхий цүнх бэлэг болгон гардуулсан. Бэлтгэл ангийн сурагчид болон тэдний эцэг эхчүүд бидний бэлгийг баяртайгаар хүлээн авсан. Ном унших уралдаанд оролцож олон ном уншсан сурагчиддаа болон тэднийг ном уншихад нь дэмжин урамшуулж мөнгөн хандив өгсөн бүх эцэг эхчүүд, төрөл төрөгсөд, багш нартаа баярлалаа.

ЭББүлгийхэнд Намрын Баярын сугалааны тохиролд Шагнал хандивлах байгууллага хамт олон хэрэгтэй байна.

Манай сургуулийн Намрын Баяр есөн сард болно. Энэ баярын үеэр сугалааны тохиролд олгох шагнал хандивлах байгууллага хамт олон бидэнд хэрэгтэй байна. Өнгөрсөн хугацаанд бид сугалааны тохиролд гоо сайхны салоноор үйлчлүүлэх эрхийн бичиг, бялдаржуулах төвийн гишүүнээр элсэх эрх, оройн хоол идэх урилга, зочид буудалд амрах эрх зэрэг олон шагналуудыг олгодог байсан. Та бүхэн УБ-т бизнес эрхэлдэг бөгөөд Намрын Баярын сугалааны тохиролд шагнал хандивлах хүсэлтэй бол Michele Moller-той michelemoller@yahoo.com хаягаар холбогдоорой.

Хаяж Гээсэн Эд Зүйлс

Сурагчдын хаяж гээсэн хувцас, хоолны сав гэх мэт эзэн нь олдоогүй олон зүйлс бидэнд цуглаараад байна. Ирэх долоо хоногуудад хаяж гээсэн зүйлс байвал шалгаарай гэж сурагчдад анхааруулна уу. Хичээлийн жилийн төгсгөлд эзэн нь олдоогүй эд, зүйлсийг бид асрамжийн газарт хандивлах болно.